



ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН ТУШААЛ

2011 оны 6 сарын 21 өдөр

Дугаар 148

Улаанбаатар хот

Нөөц бүртгэх тухай

Монгол Улсын Засгийн Газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалт, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2011 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 06 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дорнод аймгийн Тамсагийн сав газар дахь Тосон-Уул XIX талбайн Т19-78, Т19-67-2, Т19-53, Т19-80, Т19-55, Т19-7-1, Т19-52, Т19-46, Т19-20, Т19-69-5, Т19-7-1, Т19-28, Т19-51-3, Т19-56, Т19-57, Т19-69-3, Т19-120, Т19-62 блокуудын газрын тосны геологийн нөөцийг 60,06 сая тонн (452,957,200 баррель), үүнээс ашиглах боломжтой газрын тосны нөөцийг 6,50 сая тонн (49,028,210 баррель), тосонд ууссан хийн нөөцийг 4,40 тэрбум м³, үүнээс тосонд ууссан хийн ашиглалтын нөөцийг 0,47 тэрбум м³ тус тус баталгаат зэрэглэлээр Монгол Улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгэхийг Ашигт малтмалын газар /Д.Батхуяг/-т даалгасугай.
2. Тосон-Уул XIX талбайн нөөцийг баталгаат зэрэглэлээр бүртгэсэнтэй холбогдуулан 2010 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 41 дүгээр тушаалаар бүртгэгдсэн магадтай (probable) зэрэглэлийн нөөцийг 16.81 сая тонн, тосонд ууссан хийн нөөцийг 0,33 тэрбум м³ гэж шинэчлэн бүртгэхийг Ашигт малтмалын газар /Д.Батхуяг/-т даалгасугай.
3. Тосон-Уул XIX талбайд байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны геологийн нөөцөөс хайгуулын хугацаанд олборлосон газрын тосны хэмжээг хасаж тооцох, нэмэлт хайгуул-туршилтын ажил явуулж ордын нөөцийг нэмэгдүүлэх, цаашид жил бүр нөөцийн хөдөлгөөнийг хийж АМГ-ын Геологийн мэдээллийн санд бүртгүүлж байхыг Газрын тосны газар /Д.Амарсайхан/ болон "Петроочайна Дачин Тамсаг" ХХК-д тус тус даалгасугай.
4. Геологи, структурын хувьд Тосон-Уул XIX талбайд тогтоогдсон Цагаанцав формацийн Т19-62 блокийн газрын тосны нөөц Матад-XX талбайд үргэлжлэх бүрэн боломжтойг харгалзан Матад-XX талбайн тухайн хэсэгт ("ПетроМатад" ХК) хайгуулын ажил хийгдэж дууссан нөхцөлд, Газрын тосны тухай хуулийн хүрээнд зохицуулах хүртэл дээрх блокод ашиглалт явуулахгүй байхыг Газрын тосны газар /Д.Амарсайхан/ болон "Петроочайна Дачин Тамсаг" ХХК-д үүрэг болгох,
5. Хайгуулын ажлын тайлан, холбогдох бусад материалууд болон анхдагч (зураг, зүсэлт, геофизикийн судалгааны ажлын тоон мэдээлэл, чөмгөн дээж болон тосны физик, химийн шинжилгээний үр дүн гэх мэт) материалуудыг нэг бүрчлэн Газрын тосны газарт ирүүлэхийг "Петроочайна Дачин Тамсаг" ХХК-д

08000430


даалгах, түүний хэрэгжилтэнд хяналт тавихыг Газрын тосны газар /Д.Амарсайхан/-т хариуцуулах.

6. "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-д дараах зүйлсийг даалгасугай. Үүнд:

6.1. "Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журам"-ын 15 дугаар зүйлийн 1 дэх заалт, Тосон-уул XIX гэрээт талбайд байгуулсан БХГ-ний 5.4 дүгээр заалтын "б" хэсэг, 8.5 дугаар заалтын дагуу, мөн ЭБЭХСайдын 2010 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 41 дүгээр болон энэхүү тушаалыг үндэслэн ордын баталгаат зэрэглэлийн нөөцөд тулгуурлан Тосон-уул XIX талбайн газрын тосны ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/ боловсруулж ЭБМЗ-д ирүүлэх,

6.2. Хайгуулын ажлын нэгдсэн үр дүнгийн тайланг Газрын тосны газар болон Ашигт малтмалын газрын Геологийн мэдээллийн санд тус тус хүлээлгэн өгөх;

7. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Түлшний бодлогын газар /А.Эрдэнэпүрэв/ болон Газрын тосны газар /Д.Амарсайхан/-т тус тус даалгасугай



САЙД ДОРЖИГТ